



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл
2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООДЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-8

1. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны
тогтоолын төсөл

4-8

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 10 дугаар сарын 22-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 59 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Алдаржавхлан, Да.Цогтбаатар, Б.Мөнхсоёл;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ж.Батсуурь, Х.Булгантуяа, П.Ганзориг,
Ц.Даваасүрэн, П.Сайнзориг, Ч.Номин, Г.Тэмүүлэн, Д.Үүрийнтуяа;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар.

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хариуцсан референт С.Төрмөнх нар байлцав.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Байнгын хорооны дарга Х.Ганхуяг танилцуулав.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Х.Ганхуяг: 1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулъя гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	3
Бүгд:	15

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн ахлагчаар Байнгын хорооны дарга Х.Ганхуяг, гишүүдэд Улсы Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Р.Батболд, Д.Жаргалсайхан, Д.Батбаяр, Б.Заяабал, Х.Жангабыл, П.Мөнхтулга, Г.Тэмүүлэн нар ажиллахаар тогтов.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Байнгын хорооны дарга Х.Ганхуяг танилцуулав.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайханы тавьсан асуултад Байнгын хорооны дарга Х.Ганхуяг хариулж, тайлбар хийв.

Х.Ганхуяг: 2.“Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, гишүүдэд М.Бадамсүрэн, Г.Ганбаатар, Ж.Баясгалан, Да.Цогтбаатар, Г.Лувсанжамц, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, Д.Энхтүвшин нар ажиллахаар тогтов.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Х.Ганхуяг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Х.Ганхуяг хариулж, тайлбар хийв.

Х.Ганхуяг: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 28 минут үргэлжилж, 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр 13 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их засаг” танхим 12 цаг 59 минут

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Х.Ганхуяг: Байнгын хорооны гишүүд танхимдаа цугларна уу. Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 51.7 хувь буюу 29-өөс 15 гишүүн хүрэлцэн ирсэн тул Төсвийн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Өнөөдрийн ирцийг танилцуулбал Тилеуханы Аубакир, Жигжидийн Батжаргал, Хассуурийн Ганхуяг, Загджавын Мэндсайхан, Банзрагчийн Түвшин, Далайн Батбаяр, Жадамбаагийн Баясгалан, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Пүрэвбаатарын Мөнхтулга, Баттогтохын Чойжилсүрэн, Ренчиндоржийн Батболд, Хөххүүгийн Болормаа, Батжаргалын Заяабал, Даваахүүгийн Пүрэвдаваа, Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна аа.

Өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудал.

1. [Байнгын хорооны тогтоолын төсөл Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай.](#)

Хэлэлцэх асуудалдаа орёё.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5-д Байнгын хороо шаардлагатай бол хууль, тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий гишүүдээс бүрдсэн ажлын хэсгийг дангаар буюу хамтран байгуулж энэ асуудлаар Байнгын хорооны тогтоол гаргана гэж заасны дагуу Монгол Улсын 2026 онд Төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээ байгуулна аа.

Дээрх ажлын хэсэг нь Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиудыг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий мөн 2026 оны төсөвтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий гэсэн 2 ажлын хэсэг байгуулагдна.

Тогтоолын төслийг та бүхэнд танилцуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Төсвийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Х.Ганхуяг,

Ажлын хэсгийн гишүүдэд Алдаржавхлан МАН, Р.Батболд Иргэний Зориг Ногоон нам, Д.Жаргалсайхан АН, Далайн Батбаяр АН, Заяабал МАН, Жангабыл МАН, Мөнхтулга АН, Ганзоригийн Тэмүүлэн МАН-ын гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулна аа.

Хоёр дахь ажлын хэсэг бол Төсвийн хуулийг дагах хууль болон тогтоолын төслүүд дээр ажиллах ажлын хэсэг байгаа. Үндсэндээ 2 ажлын хэсэг байгуулагдана гэсэн үг.

Нэг нь болохоор төсөвтэй холбоотой, нөгөөдөх нь төсөв дагах тогтоол болон хуулийн төслүүд дээр ажиллана гэсэн үг.

2.Монгол Улсын 2026 онд Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Үүрийнтуяа, Ажлын хэсгийн гишүүдэд Бадамсүрэн, Гомбын Ганбаатар, Ж.Баясгалан, Ганзориг, Лувсанжамц, Мэндсайхан, Пүрэвдаваа, Энхтүвшин нарын бүрэлдэхүүнтэй энэхүү захирамжийн 1, 2 дахь заалтад заасан хууль тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга Төсвийн байнгын хорооны хуралдаан тус тусдаа танилцуулахыг ажлын хэсгийн дарга нарт үүрэг болгосугай

4.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтан, мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах, судалгаа тайлан мэдээлэл болон бусад баримт бичгийг гардуулан дүн шинжилгээ хийлгэх ажлын хэсэг зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч нар зөвшөөрсүгэй.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан санал гаргах гишүүн байна уу? Батжаргал гишүүнээр тасаллаа.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Энэ сүүлийн үед л төсөв дээр дагасан хууль тогтоомж дээр ийм тусдаа ажлын хэсэг байгуулагдаад, гарч байгаа дүгнэлтүүд нь хоорондоо уялдаж өгөхгүй юмнууд яваад болж өгөхгүй байгаад байгаа юм аа.

Тийм учраас төсөв дагасан хууль тогтоомжуудаа нэг ажлын хэсэгтэй, харин ажлын хэсэг нь дотроо чиг үүргийнхээ хүрээнд төсөв дээрээ энэ хэсэг нь сууя, дагасан хууль тогтоомж дээрээ энэ хэсэг нь сууя гэдгээ шийдээд ажлын хэсэг дээрээ тэр 2 чиг үүрэг хүлээсэн бүрэлдэхүүнийхээ санал, дүгнэлтийг хэлэлцээд нэгдсэн байдлаар санал, дүгнэлт нь орж ирвэл л төсөв дагасан хууль тогтоомжуудын уялдаа холбоо бүрэн хангагдаж гарч ирэх ёстой гэж ингэж ойлгоод байгаа. Би төсвийн тодотгол дээр энэ байдал их тодорхой харагдсан байхгүй юу.

Тийм учраас тэр тодорхой газар нутгийг улсын тусгай хамгаалалтаас гаргаж болохоор заалт дагасан хууль тогтоомжийн асуудалд орсон дээр Ерөнхийлөгчийн тавьсан хориг чинь бол үндсэндээ тийм санаа агуулагдчихсан байхгүй юу. Тэгэхээр энийг бид ер нь анзаарах ёстой юу үгүй юу? Энэ дээр Байнгын хороон дарга ер нь ямархуу байр суурьтай байна вэ гэж.

Х.Ганхуяг: Ер нь төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг Байнгын хороо байгуулж байгаа тохиолдолд ажлын хэсгийг Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн харилцааг харгалзан 10 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж болно оо гэж заачихсан байгаа.

Тэгэхээр бид нар 9 гишүүнээр 2 байнгын хороо ажлын хэсэг байгуулахаар санал оруулж байна. Тухайн хууль, тогтоолын төслийг хэд хэдэн Байнгын хороонд хуваарилсан. Байнгын хороонд хамтарч болно оо гэсэн байгаа. Ажлын хэсгийн ахлагчид холбогдох Байнгын хорооноос нэг гишүүн нэр дэвшвэл, шууд нэгээс илүү гишүүн нэр дэвшвэл илээр санал хурал явуулж болно оо. Олонхын санал авсан гишүүнийг ахлагчаар томилж болно оо гэж байгаа юм.

Бид нар энэ удаа Их Хурлын даргын захирамжаар биш Байнгын хорооноос байгуулж байгаа шалтгааныг та бүхэн бүгдээрээ гадарлаж байгаа байх. ҮХЦ дээр маргаан үүсчихсэн явж байгаа болохоор Байнгын хороон дээр ажлын хэсэг байгуулахаас өөр аргагүй болчхоод байгаа юм. Тэгэхээр 9 гишүүнээр хязгаарлалцахаар үндсэндээ нөгөө гишүүдийн ажлын хэсэгт оръё гэсэн санал нь хязгааргүй их байна.

Тийм учраас 2 ажлын хэсэг болоод л ажиллахаас өөр аргагүй болчхоод байна. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг бид нар Байнгын хороон дээрээ хэлэлцэнэ, чуулган дээрээ хэлэлцэнэ. Бүх байнгын хороон дээр хэлэлцэх тул энэ удаа бид нар ингээд 2 ажлын хэсэг байгуулаад явахаас өөр аргагүй л нөхцөл байдалтай болчхоод байна Батжаргал гишүүн ээ. Баярлалаа.

Одоо санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье.

9 гишүүнтэй ажлын хэсэг байна гэсэн үг. Энэ болохоор нөгөө намын олонх цөөнхийн харьцаагаа харгалзаж заавал ч үгүй явах ёстой. Энэ Улсын Их Хурлын хуулиар. Тэгэхээр 9 гишүүн дотроо 5 гишүүн нь МАН, 3 гишүүн нь АН-аас, 1 гишүүн нь цөөнхөөс нөгөө бүлэггүй цөөнхөөс гэсэн үг.

Ингээд харахаар одоогийн байдлаар орж ирсэн байгаа саналуудыг томьёолбол төсвийн ажлын хэсэг дээр Ганхуяг, Алдаржавхлан, Заяабал, Жангабыл, Тэмүүлэн гээд ийм МАН-аас, АН-аас 3 гишүүн байна. Жаргалсайхан, Далайн Батбаяр, Мөнхтулга гэсэн 3 гишүүн байна. Иргэний Зориг ногоон намаас Батболд гишүүн байна.

Төсөв дагасан ажлын хэсэг дээр Үүрийнтуяа, Бадамсүрэн, Лувсанжамц, Мэндсайхан, Энхтүвшин нар МАН-аас, Гомбын Ганбаатар, Баясгалан гишүүн та өөрөө АН-аас, Ганзориг гишүүн ХҮН намаас, Пүрэвдаваа гишүүн Үндэсний эвслээс гээд ийм бүрэлдэхүүнтэй 2 ажлын хэсэг байгуулагдана гэсэн үг.

Г.Ганбаатар, Баясгалан. Энэ дээр нээрээ нэг гишүүн алдчихсан байна шүү дээ. Тэгвэл ингэе. Ингэчихье. Эхнийхийгээ эхний ажлын хэсгийнхээ санал хураалтыг явуулчхаад, дараагийнх дээр та ажил АН-аас нэг гишүүн дэвшүүлчихвэл бид нар санал хураалтаар шийдчихье тэгэх үү.

Гишүүд санал хураалтад бэлэн бол санал хураалт явуулъя.

15 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 80 хувийн саналтайгаар эхний ажлын хэсэг байгуулагдсан байна.

Хоёр дахь нь хаана байна?

Хоёр дахь дээр нь Ганзориг гишүүн юм уу Пүрэвдаваа гишүүний оронд АН-аас нэг хүн санал болгоод санал хураалт явуулж болно.

Байнгын хорооны гишүүн байсан ч болно, гишүүн биш байсан ч болно гэсэн үг. Хэний оронд вэ гэдэг дээр явах ёстой. Та шийднэ шүү дээ. Үгүй би шийдэхгүй АН-аас өөрснөө яг энэ гишүүний оронд бид нар энэ хүнээ дэвшүүлээд байж байна гээд санал болгоно гэсэн үг.

Яах вэ угаасаа энэ чинь бид нар нөгөө ажлын хэсэгт санал угаасаа 2 тогтоолын төсөл, 2 хууль байгаа. Тэгээд Байнгын хороогоор хэлэлцэнэ. Тэгэхээрээ та нар өөрсдөө бүгдээрээ тэрэн дээрээ саналаа оруулаад явах боломжтой байхгүй юу. Түвшин гишүүнийг оруулах юм уу? Ганзориг гишүүн юм уу, Пүрэвдаваа гишүүний аль нэгэн дээр та нар санал болгоод яачихвал. Санал хураачихъя.

Тэгвэл Ганзориг гишүүний оронд.

Жаргалсайхан гишүүний микрофон өгье.

Д.Жаргалсайхан: АН-ын бүлгээс санал дэвшүүлнэ. АН-аас 3, 3 төлөөллийг хангах үүднээс нэг гишүүнийг солиод, АН-ын төлөөллийг оруулж өгнө үү гэсэн ийм хүсэлт байна.

Тийм учраас Ганзоригийн гишүүний оронд Цогтбаатар гишүүнийг оруулах саналтай байна. Төсвийн байнгын хорооны гишүүн Цогтбаатар Даваагийн Цогтбаатар гишүүнийг оруулах саналтай байна аа.

Х.Ганхуяг: Жаргалсайхан гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэнэ үү?

Томьёоллыг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Ганзориг гишүүний оронд Даваагийн Цогтбаатар гишүүнийг санал болгосон тул санал хураалт явуулъя.

Энэ чинь би орчихсон байна уу, ороогүй байна уу? Санал хураалтыг танилцуулъя.

15 гишүүнээс 12 гишүүн дэмжиж 80 хувийн саналтайгаар дэмжигдсэн тул санал хураалтыг баталъя. Тэгвэл дахиад батлагдсан тогтоолыг та бүхэнд танилцуулъя.

2.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч Үүрийнтуяа, гишүүд Бадамсүрэн, Гомбын Ганбаатар, Баясгалан, Даваагийн Цогтбаатар, Лувсанжамц, Мэндсайхан, Пүрэвдаваа, Энхтүвшин нарын бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсгийг байгуулсугай.

Энэхүү захирамжийн 1, 2 дахь заалтад заасан хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга Төсвийн байнгын хорооны хуралдаанд тус тусдаа танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч Ганхуяг, Үүрийнтуяа нарт үүрэг болгосугай.

4.Ажлын хэсэг мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтан, мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах судалгаа, тайлан мэдээлэл, бусад баримт бичгийг гаргуулан дүн шинжилгээ хийлгэх ажлыг зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч Ганхуяг, Үүрийнтуяа нарт зөвшөөрсүгэй.

Тэгээд тогтоолын төслийг батлахаар санал хураалт явуулна.

Санал хураалт.

15 гишүүнээс 12 гишүүн дэмжиж санал өгсөн байна аа.

Байнгын хорооны тогтоолыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

13.16 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА